

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гомбын Галсан	Дугаар	L015
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Сүхбаатар дүүрэг
Төрсөн газар	Говь-Алтай аймаг	Төрсөн он	1917
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Усан Зүйлийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ГАТХ 108
Одоогийн сүм хийд	Дамбадаржаалин хийд	Сүм хийдийн дугаар	UB 07
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 5	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Говь-Алтай аймгийн Тонхил сумын Усан зүйлийн хүрээ

Би 8- н настайгаасаа лам болсон. Манай хоёр ах тэнд суудаг байсан. Зүйлийн гол, Цаст богдын тэнд байдаг байсан. Усан зүйлийн хүрээ 1000 гаран ламтай. Говь-Алтай аймгийн Тонхил сумын төвийн яг хажууд байсан. Цаст Богдыг тахидаг байсан. 1935 оны намар хаагдсан. Хантайшир аймгийн Жалчин бэйсийн хошууны нутаг. 1800-аад онд байгуулагдсан. 13 дугантай байсан. Чойр, Жүд, Цогчэн, Манба, Нүгнээ, Дүйнхор, Жанрайсагийн дуган, Жавжиа хангал, Дарь эх, Ганжуур, Ламтан, Аймгийн, Дордов гэсэн.

Цорж лам нь Боржорвон гэж хүн байсан. Чойламсан, Жанчивчойдог, Ламжав унзад гэж хүмүүс байсан. Гол шүтээн нь Эрдэнэдавга гэж ном байсан. Арван Хангал тахидаг байсан. Лам нар нь голчлон Жалчин бэйсийн хошуунаасаа шавилан суудаг байсан. Пэрэнлэй гэж хувилгаан хүн байсан. Түвдэнням гэдэг хувилгаан байсан. Манайд хоёр төвд багш байсан. Нэгийг нь Боржорвон гэдэг байсан. Би ном заалгаж байсан. Чойр, Дүйнхор, Манба гэсэн сургалтын дацангууд байсан. Ном хэвлэдэг бартай. Ганжуур, Данжуур, Сандуйн жүд ч барлана. Дандаа төвдөөр барлана.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цогчэн хурал тасрахгүй хурна. Цогчэндоо 10 хангал хурна. Шинийн 8-нд Манла, 30-нд Сандуйн жүд, 15-нд Ламрим човд хурна. Цагаан сараар битгүүндээ Лхам тахиж данраг өргөнө, сор зална. Цагаан сарын дараа магтаал хурна. Цам зуны эхэн сард гардаг байсан. Арван Хангал цугаараа гардаг байсан. Майдар зуны эхэн сард эргэнэ. Сүсэгтнүүд их ирнэ. Майдараар цам гарна. Ганжуураа үүрээд хүрээгээ тойрно. Горооны зам гэж байсан. Нутгийн дээсээр Ганжуур эргэнэ. Бурхан багшийн дүйчэн өдрөөр хурал хурна. Зулын 25-нд Хангал хурна. Хайланг гэлэн лам нар 300-д лам нар 45 хоног хурна.

Би Цогчэнд хурж байгаад Чойрт орсон. Би умын дом тавьсан. Чойрын игчаа нь Банчэн ламаар явдаг байсан. Манай зиндаа 43 ламтай байсан. Жорвон нь Оросоо гэдэг хүн байсан. 10 жил болоод дом тавина. Гавжийн дамжааг жилд нэг удаа намар барина. Домыг өвөл хурна. Манай зиндаанаас одоо үлдсэн хүн алга. Чойр дацанд өглөө хурдаг. Өдөрт 2 тасалж хурна.

Чулуугаар бариад гадна талыг нь шавардчихсан дуганууд байсан. Давхар сүм байгаагүй. Ламтаны дуган нь модон дуган байсан. Хүрээний гадна талаар шавар хэрэмтэй байсан. Хүрээнийхээ хоёр талаар суудаг, зүүн талаар нь харчууд, баруун талаар нь лам нар сууна. Зүйлийн гол гэж их том гол байх. Зүйлийн голын тэрүүгээр Хятад пүүстэй байсан. Цоохор далай, Баяндалай гэсэн улсууд байсан.

Манай хийдээс хойш 30-д км зайд Хөхөрийн хүрээ байсан. Маш сайхан цамтай газар байсан. Лам нар нь ирж очдог байсан. Цамын дэг жаягийг манайх Хөхөрийн хүрээнээс авсан байх. Манайхаас Төвд рүү явж сурч байсан юм байна. Манай нэг нагац ах Чойдог гэдэг хүн Төвдөд байж байгаад Энэтхэгт очоод тэгээд аграмба болоод хүрээд ирсэн тийм хүн байсан юм. Хүрээндээ маарамбын дамжаа Манба дацанд тавьж, Чойртоо гавж болж, Жүдэд аграмба болдог байсан.

7-н жастай. Цогчэн Чойр жасууд их баян. Тэгээд Жүдийнх орно. Хийд дээр зоч нар, лүйжинч нар байсан. Тусгай дугантай байсан. Тэрийг нь Ламтаны дуган гэж нэрлэдэг байсан.

Сүсэгтнүүд намар их ирнэ. Дом тавихаар их ирнэ. Цам, Майдараар их ирнэ. Тэр үеийн лам нар сүсэгтнүүдийн хоорондын харилцаа их сайхан байсан.

Дотоод Явдлын яамнаас Жигжидсүрэн гэдэг хүн ирж хаасан. Бурхан тахилыг нь ачаад явсан. Чулуу шавар хоёроор барьсан. Би хар болсноосоо хойш санхүүгийн ажил хийсэн. 1937 онд Завханд байж байгаад цэрэгт явсан. 1947 онд Улаанбаатарт ирсэн. Худалдаа бэлтгэлийн яаманд ажиллаж байсан. Өмнө нь Ганданд хурж байсан. Би Дамбын хийдэд 1996 онд ирсэн. Шашин улам л хөгжих болтугай л гэж бодож сууна.

Би Төв аймгийн Дамбын хүрээнд сууж байсан. 1930н хэдэн онд хар болсон. 1919 онд төрсөн, 7,8 н настайгаасаа хүрээнд суусан. Дамбар-Эрдэнэ хутагт 1935 онд баригдаад явсан. Дуган бүр 100-гаад ламтай, 7н дугантай. Чогчин, Жүд, Дүд, Мамбын, Лүд, Төгсөн, Самбий. Дээд сүмдээ бурхан тахил байна. Нэг суварга босгосон, төвд нэр байгаагүй. Эрээнтэй гэдэг уул байсан. Дамбар-Эрдэнийн хийдэд төвд нэр байгаагүй. Цэгмид гэдэг хутагт байсан. Миний овог Гонгор Шавь-далайн хошуу. Хийдийн гол шүтээн нь Дамдин. Манай Дамбар-Эрдэнэ багш нэг настайгаасаа тодорсон. Ээжийг нь Сийлэгмаа гэдэг байсан. Дээд лам нь Бамбар –Эрдэнийн өмнөх дүр. Хийдийн уншлага өдөр тутам Чогчин, Санжид уншина. Шинийн 15 нд Жүд, 8 нд Манал, 29нд арван

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хангал уншина. Бурхан багшийн дүйцсэн өдрөөр Лхам уншина. Богд ламын дүйцсэн өдрөөр Чилхаан, битүүнд Цэдэр хурна, ерөөл уншина, Цам гардаг байсан. Цагаан сараар цам гарна сор зална, Майдар эргэдэг байсан. Ганжуураар хүрээгээ тойрч эргэдэг байсан. Нүгнээг нэг сар хурна. Хайлан хурна, үүнд 20-30н лам суудаг 45 хоног үргэлжилнэ.Шавар, Чулуу байсан байх. 1934 онд шатсан. Ахиж дуган нэмж бариагүй. Би жүдэд ороод нэг жил болоод хар болсон. Жүдэд суралцаад хамба болж байсан. Дугаржав гэж хамба байсан. Унзадүүд зөндөө. Манай хийдийн ойролцоо хийд байгаагүй. Манайд төвд лам байгаагүй Хийд хэрмэн хашаа бараг байхгүй суварагууд ихтэй байсан. Лам нарын гэр орон нь хоёр талаараа байдаг. Аймаглаж суудаг, энгийн айлууд ойролцоо зөндөө байдаг. Нэг жастай, жас нь өргөл барьж амьдардаг байлаа. Тэр үеийн лам нарын өдөр тутмын амьдрал нь хурлаа хурна. Хандмаа нар бараг байгаагүй. Сүм хийдийн ойролцоо хятад наймаа байсан. Манай хийд 1935 онд хаагдсан. Би 1937-1938 онд цэрэгт явсан. Хийдийн ном судрыг хүмүүс аваад явсан. 50 гаран хүн баригдсан. Дорж гэж надаас хоёр ах хүн бий. Дэчинравжаалан хийдэд ирээд удаагүй,одоо 3 жил болж байна. Хойд энгэрт 3 суварга байсан. үнээгийн овоог тахидаг байсан. Зүүн талд Чогчин дуган, ерөнхийдөө нэг давхар, түүний баруун талд Жүдийн дуган, түүний хойно Мамбын дуган байсан.

Нүгэл буяныг ялгаж мэдэх ариун сайхан сэтгэл мэднэ. Хийд улам сайхан дэлгэрч хөгжөөсэй.